



Монгол аврагчид олон улсын зэрэглэлтэй боллоо

Х.БОЛОР

Гүний шумбалтын олон улсын зэрэг олгох сургалтыг манай 16 усчин-аврагч амжилттай дүүргэж, “Усан доогуур шумбагч”-ийн нэг одны зэрэглэл хангажээ. Тэдэнд өчигдөр олон улсын усчин-аврагчийн гэрчилгээ гардууллаа.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах, менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төсөл Онцгой байдлын ерөнхий газартай хамтран манай улсын усчин-аврагчдад өвлийн нөхцөлд усны гүнд шумбах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх сургалтыг 2010 оны арванхоёрдугаар сард зохион байгуулжээ. Сургалтыг дээрх төслийн зөвлөх ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Нуур судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, ОХУ-ын усан доогуурх үйл ажиллагааны нийгэмлэг, Усан доогуурх сэлэлтийн сургалтын төвийн сургагч багш, биологийн ухааны дэд доктор А.Б.Купчинский удирдан явуулсан байна. Сургалтад ОБЕГ-ын Аврах тусгай анги, нийслэлийн Аврах отряд, Багануур, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дорнод аймгийн 16 усчин-аврагч хамрагджээ. Тэд гүний шумбалтын онолын хичээл судалж, олон улсын стандартын шаардлага хангасан тусгай хувцас, багаж, хэрэгсэл ашиглан өвлийн нөхцөлд усны гүнд эрэн хайх туршлагаа улам арвижуулсан аж. Энэ сургалтад хамрагдсан аврагчид Хөвсгөл нуурт живсэн шатахуунтай машиныг татаж гаргасан юм.